

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР БАТЗОРИГТЫН ЭРДЭНЭБАТЫН ТОВЧ НАМТАР



Хэзээ, хаана төрсөн: 1964 онд Улаанбаатар хотод төрсөн. Луу жилтэй.

Хаана, ямар сургуульд суралцаж төгссөн: 1972-1982 онд Нийслэлийн 10 жилийн 24 дүгээр дунд сургууль
1983-1986 онд ЗХУ-ын (хуучин нэрээр) Цэргийн нисэхийн нэгдсэн сургууль
1993-1998 онд ОХУ-д Профессор Н.Е.Жуковскийн нэрэмжит Агаарын Цэргийн Инженерийн Академи
1998-2001 онд ОХУ-д Цэргийн Нисэхийн Техникийн Их Сургуулийн докторантур
2005 онд ХБНГУ-д “Олон улсын аюулгүй байдлын дээд албан тушаалтны дамжаа”
2007 онд АНУ-ын БХ-ын “Гадаад хэлний институт”-д англи хэлний гүнзгийрүүлсэн дамжаа
2007 онд АНУ-д “Батлан хамгаалахын нөөцийн менежментийн дээд албан тушаалтны дамжаа”
2012-2013 онд “Alliance Francaise de Mongolie” төвийн франц хэлний дамжаа
2013 онд APSCO-гийн (Asia - Pacific Space Cooperation Organization) дадлагын бүрэн курсийг тус тус дүүргэсэн.

Мэргэжил, боловсрол: Цэргийн дээд боловсролтой, хурандаа цолтой офицер. Нисэх аппарат - тийрэлтэт хөдөлгүүрийн инженер мэргэжилтэй. Орос, англи хэлтэй.

Зэрэг, цол: Техникийн ухааны доктор (Ph.D), профессор. Техникийн спортын чөлөөт нислэгийн F1C төрөлд “Олон улсын хэмжээний мастер”, “Ази тивийн аварга”, Дэлхийн аваргын мөнгөн медальт.

Ажил, албан тушаал: 1982-1983 онд Хугацаат цэргийн албан хаагч, байлдагч
1986-1993 онд Ардын армийн сөнөөгч онгоцны нисэх тусгай хороонд онгоц - хөдөлгүүрийн техникч, ахлах техникч, ахмад
2001-2003 онд ЗХЖШ-ын Агаарын Довтолгооноос Хамгаалах Цэргийн Командлалд Штабын дарга, командлагчийн орлогч, хурандаа
2003-2007 онд Батлан хамгаалахын дэд сайд
2002-2011 онд ШУТИС, МИС Аэро-гидромеханикийн профессорын багийн профессор, тэргүүлэх профессор, ШУТИС-ийн УЗ-ийн гишүүн
2011-2012 онд ШУТИС, Механик Инженерийн Сургуулийн захирал
2012-2013 онд Улс төрийн ууган хүчин МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга У.Хүрэлсүхийн орон тооны зөвлөх
2013 оноос ШУТИС Механик Тээврийн Сургуулийн профессор.
2021 оноос ҮБХИС Батлан хамгаалах удирдлагын академийн ахлах багш.

Одоо хашиж байгаа сонгуульт ажил: БХЯ, ЗТХЯ-ны Шинжлэх Ухаан, Технологийн Зөвлөлийн гишүүн
ҮБХИС, ШУТИС-МехТС-ийн Эрдмийн Зөвлөлийн гишүүн
БШУЯ-ны дэргэдэх Механик Инженерийн Докторын Зэрэг Хамгаалуулах Зөвлөлийн гишүүн
ННМЭ, Монгол Оросын найрамдлын нийгэмлэгийн дэд тэргүүн.